

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/577
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Соёлын өвийн үндэсний төв нь тайлант онд 16 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>188,568,799.16</u>	<u>194,027,346.20</u>
33	АВЛАГА	27,681,812.80	18,434,058.80
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	18,434,058.80
335	Бусад авлага	27,681,812.80	00.00
3351	Байгууллагаас авах авлага	27,681,812.80	00.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	36,490,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	36,490,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	160,886,986.36	139,103,287.40
354	Хангамжийн материал	160,886,986.36	139,103,287.40
35410	Бичиг хэргийн материал	3,070,290.00	3,008,700.00
35420	Аж ахуйн материал	124,535.00	727,980.00
35430	Сэлбэг хэрэгсэл	320,000.00	320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	429,000.00	396,000.00
35450	Барилгын засварын материал	5,288,570.00	5,720,400.00
35470	Бусад хангамжийн материал	151,654,591.36	128,930,207.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>516,293,751.34</u>	<u>346,286,396.64</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	516,293,751.34	346,286,396.64
392	Биет хөрөнгө	397,831,706.40	229,435,463.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,000,000.00	10,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,600,000.18	-10,000,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	268,500,000.00	183,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-233,886,111.74	-169,625,000.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,492,305,944.48	1,494,305,944.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	1,307,133,205.47	-1,434,129,134.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	263,776,292.03	263,776,292.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-93,956,972.72	-115,724,698.40
39217	Ном	6,825,760.00	7,332,060.00
393	Биет бус хөрөнгө	118,462,044.94	116,850,933.44
39301	Програм хангамж	91,770,000.00	93,970,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-76,225,555.06	-80,036,666.56
39303	Бусад биет бус хөрөнгө	102,917,600.00	102,917,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>704,862,550.50</u>	<u>540,313,742.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>90,640.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	90,640.00
413	Өглөг	00.00	90,640.00
4136	Бусад өглөг	00.00	90,640.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	90,640.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	704,862,550.50	540,223,102.84
51	Засгийн газрын хувь оролцоо	704,862,550.50	540,223,102.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	796,011,906.63	796,011,906.63
51101	Өмч: - төрийн	796,011,906.63	796,011,906.63
512	Хуримтлагдсан үр дүн	-91,149,356.13	-255,788,803.79
51210	Өмнөх үеийн үр дүн	-91,149,356.13	-91,149,356.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-164,639,447.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	704,862,550.50	540,313,742.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	803,554,921.00	854,815,047.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,916,875.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,916,875.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,916,875.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,916,875.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	803,554,921.00	852,898,172.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	637,337,700.00	698,742,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,337,700.00	698,742,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,217,221.00	154,155,672.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	136,477,221.00	64,248,672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,800,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,940,000.00	69,907,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	985,617,839.92	1,017,093,383.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,617,839.92	1,017,093,383.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,939,348.99	886,122,035.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,783,567.00	446,414,058.27
210101	Үндсэн цалин	282,102,827.00	279,268,444.70
210102	Нэмэгдэл	81,086,703.00	139,208,721.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,594,037.00	27,936,892.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,853,226.13	57,313,969.37
210201	Тэтгэврийн даатгал	40,720,714.13	39,854,574.65
210202	Тэтгэмжийн даатгал	3,964,982.00	4,620,098.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,171,983.00	3,578,479.99
210204	Ажилгүйдлийн даатгал	689,298.00	837,006.87
210205	Эрүүл мэндийн даатгал	7,306,249.00	8,423,809.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,446,079.58	63,256,633.26
210401	Бичиг хэрэг	4,124,677.80	1,843,510.00
210402	Тээвэр, шатахуун	20,604,780.00	7,407,132.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,677,852.14	3,711,853.30

210404	Ном, хэвлэл	10,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,513,450.00	1,186,019.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	39,515,319.64	49,108,118.96
2105	Нормативт зардал	375,000.00	636,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	375,000.00	636,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,639,190.00	550,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,018,500.00	00.00
210604	Урсгал засвар	8,620,690.00	550,000.00
2107	Томилолт, зочны зардал	21,840,900.00	10,896,000.00
210702	Дотоод албан томилолт	21,840,900.00	10,896,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,472,608.20	113,131,531.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,655,708.20	107,383,419.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,163,900.00	2,028,668.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	730,000.00	724,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	243,000.00	176,000.00
210807	Газрын төлбөр	680,000.00	819,344.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,267,478.08	172,662,543.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,294,000.00	310,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,973,478.08	172,352,543.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,678,490.93	130,971,348.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	13,675,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,265,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,678,490.93	117,295,748.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,678,490.93	117,115,748.06
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	180,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-182,062,918.92	-162,278,336.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,361,110.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,361,110.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,361,110.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-182,062,918.92	-164,639,447.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	854,946,361.00	882,496,859.80	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,916,875.00	
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,916,875.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,916,875.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,916,875.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	854,946,361.00	880,579,984.80	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	637,337,700.00	698,742,500.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,337,700.00	698,742,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,608,661.00	181,837,484.80	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	187,868,661.00	91,930,484.80	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,800,000.00	20,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,940,000.00	69,907,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	854,946,361.00	877,790,559.80	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,946,361.00	877,790,559.80	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	727,586,057.27	728,385,152.94	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,783,567.00	446,414,058.27	
210101	Үндсэн цалин	282,102,827.00	279,268,444.70	
210102	Нэмэгдэл	81,086,703.00	139,208,721.57	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,594,037.00	27,936,892.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,853,226.13	57,313,969.37	
210201	Тэтгэврийн даатгал	41,897,898.23	39,854,574.65	
210202	Тэтгэмжийн даатгал	3,552,783.84	4,620,098.27	
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,110,672.00	3,578,479.99	
210204	Ажилгүйдлийн даатгал	62,611.38	837,006.87	
210205	Эрүүл мэндийн даатгал	7,229,260.68	8,423,809.59	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00	
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	23,392,288.94	22,807,544.30	
210401	Бичиг хэрэг	2,949,630.00	3,025,810.00	
210402	Тээвэр, шатахуун	14,432,780.00	7,443,132.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,805,339.94	3,878,213.30	
210404	Ном, хэвлэл	1,516,839.00	00.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	687,700.00	8,460,389.00	

	зүйлс		
2105	Нормативт зардал	1,411,500.00	1,176,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,411,500.00	1,176,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,018,390.00	550,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,302,700.00	00.00
210604	Урсгал засвар	11,715,690.00	550,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,984,900.00	10,896,000.00
210702	Дотоод албан томилолт	18,984,900.00	10,896,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185,901,385.20	166,966,281.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,084,485.20	161,357,513.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,163,900.00	2,028,668.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	730,000.00	724,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	243,000.00	176,000.00
210807	Газрын төлбөр	680,000.00	680,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,979,500.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,979,500.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,360,303.73	149,405,406.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	13,675,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,265,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	126,360,303.73	135,729,806.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,360,303.73	119,032,623.06
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	16,697,183.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,706,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,706,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,706,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,706,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,706,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,706,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,011,906.63	00.00	90,913,562.79	886,925,469.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,011,906.63	00.00	90,913,562.79	886,925,469.42
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-182,062,918.92	-182,062,918.92
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,011,906.63	00.00	-91,149,356.13	704,862,550.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,011,906.63	00.00	-91,149,356.13	704,862,550.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-164,639,447.66	-164,639,447.66
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,011,906.63	00.00	-255,788,803.79	540,223,102.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	698,742,500.00	581,626,751.94	117,115,748.06	83.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	698,742,500.00	581,626,751.94	117,115,748.06	83.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	685,066,900.00	567,951,151.94	117,115,748.06	82.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,609,600.00	438,819,798.27	100,789,801.73	81.3%
210101	Үндсэн цалин	325,668,000.00	271,674,184.70	53,993,815.30	83.4%
210102	Нэмэгдэл	182,401,600.00	139,208,721.57	43,192,878.43	76.3%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,540,000.00	27,936,892.00	3,603,108.00	88.6%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,847,400.00	56,755,029.37	16,092,370.63	77.9%
210201	Тэтгэврийн даатгал	51,263,000.00	39,295,634.65	11,967,365.35	76.7%
210202	Тэтгэмжийн даатгал	5,396,100.00	4,620,098.27	776,001.73	85.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,316,900.00	3,578,479.99	738,420.01	82.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,079,200.00	837,006.87	242,193.13	77.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	10,792,200.00	8,423,809.59	2,368,390.41	78.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00	0.00	100.0%
210304	Байрны түрээс	21,261,300.00	21,261,300.00	0.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	17,112,300.00	17,090,612.30	21,687.70	99.9%
210401	Бичиг хэрэг	2,497,000.00	2,496,610.00	390.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,949,100.00	1,949,100.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,680,800.00	3,678,213.30	2,586.70	99.9%
210404	Ном, хэвлэл	517,500.00	506,300.00	11,200.00	97.8%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,467,900.00	8,460,389.00	7,511.00	99.9%
2105	Нормативт зардал	1,176,300.00	1,176,000.00	300.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,176,300.00	1,176,000.00	300.00	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	550,000.00	550,000.00	0.00	100.0%
210604	Урсгал засвар	550,000.00	550,000.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,510,000.00	31,298,412.00	211,588.00	99.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,693,100.00	25,689,644.00	3,456.00	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	2,163,900.00	2,028,668.00	135,232.00	93.8%

210804	Тээврийн хэрэгслийн татвар	730,000.00	724,100.00	5,900.00	99.2%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	243,000.00	176,000.00	67,000.00	72.4%
210807	Газрын төлбөр	680,000.00	680,000.00	0.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,675,600.00	13,675,600.00	0.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,675,600.00	13,675,600.00	0.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,265,600.00	11,265,600.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,410,000.00	2,410,000.00	0.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	698,742,500.00	581,626,751.94	117,115,748.06	83.2%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	698,742,500.00	581,626,751.94	117,115,748.06	83.2%
131001	Улсын төсвөөс санхүүжих	698,742,500.00	581,626,751.94	117,115,748.06	83.2%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	34	1	97.1%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	32	31	1	96.7%
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		181,837,484.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		181,837,484.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		165,140,301.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,594,260.00
210101	Үндсэн цалин		7,594,260.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		558,940.00
210201	Тэтгэврийн даатгал		558,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,223,232.00
210401	Бичиг хэрэг		529,200.00
210402	Тээвэр, шатахуун		5,494,032.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		200,000.00
2107	Томилолт, зочны зардал		10,896,000.00
210702	Дотоод албан томилолт		10,896,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		139,867,869.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		139,867,869.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		16,697,183.80
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,697,183.80
213305	Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлэг		16,697,183.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		181,837,484.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		181,837,484.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		91,930,484.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		69,907,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Энхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны и-баримтыг бүрэн бүрдүүлж, бүртгэлд тусгаж байх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Оюундулам, аудитор Д.Мядагмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Си Пи Ти Эй Аудит ХХК -д 2021 оны 01 сарын 20-ний өдрийн 01/33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Соёлын өвийн үндэсний төвийн эрхэм зорилго нь Соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үндэсний сүлжээг бий болгон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн соёл, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллага байхад оршино.

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт судалгаа хийх, сурталчлах, түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах, соёлын өвийг авран хамгаалах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Соёлын өвийн үндэсний төв 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд соёлын өвийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 2020 оны 3-р улиралд шилэн дансанд хийсэн дотоод аудитаар 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтад 15,946.00 мянган төгрөгийн зөрчил арилгах арга хэмжээг авсан байна

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,016,994.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,169.9 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд мөн нийт зардлын 1,019,454.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,194.5 мянган төгрөгөөр тогтоолоо. Материаллагийн түвшин өөрчлөгдсөн нь аудитын явцад үндсэн хөрөнгийн гарз 2361.1 мянга, элэгдлийн зардал 99.0 мянган төгрөгөөр өөрчлөгдсөнтэй холбоотой.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 164,548.8 мянган төгрөгөөр буюу 23 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	27,681.8	18,434.0	(9,247.8)
Урьдчилж гарсан зардал	00.00	36,490.0	36,490.0
Бараа материал	160,887.0	139,103.3	(21,783.7)
Үндсэн хөрөнгө	516,293.8	346,286.4	(170,007.4)
Нийт хөрөнгө	704,862.6	540,313.7	(164,548.9)
Өр төлбөр		90.6	90.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	704,862.6	540,223.1	(164,639.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	704,862.6	540,313.7	(164,548.9)

Авлага дансны үлдэгдэл 18,434.0 мянган төгрөг болж 9,247.8 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл ЮНЕСКО төсөл хөтөлбөрийн авлага 27,681.8 мянган төгрөгийг барагдуулж, тайлант онд 18,434.0 мянган төгрөгийн авлага нэмж үүссэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 160,887.0 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд 47,592.8 мянган төгрөгийн худалдан авалт, 69,376.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 139,103.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урьдчилж гарсан зардлын данс 36,490.0 мянган төгрөг болж өссөн нь Баяннуурын төслийн ном хэвлэл, Хөтөч тайлбарлагч нарт зориулсан гарын авлага хэвлүүлэх зардал, Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Хар балгасны дэргэд байрлалтай бичигт хөшөөг зөөж тээвэрлэх зардал, төмөр торон хашаа хийх зардлуудыг гэрээний дагуу урьдчилан шилжүүлсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 346,286.4 мянган төгрөг болж 170,007.4 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн хөрөнгөөр 4,706.3 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн дүнгээр нэмэгдэж, тайлант хугацаанд ТӨБЗГазрын 2020 оны 04 сарын 21-ны 134 тоот тогтоолоор Олон улсын Хүүхдийн найрамдал цогцолборт 85,000.0 мянган төгрөгийн Паз маркийн машиныг балансаас балансад шилжүүлсэн, тайлант оны элэгдлийн зардал 89,713.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 90.6 мянган төгрөг болж өссөн нь Монгол шуудан ХК-д өгөх өглөгөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 540,223.1 мянган төгрөг болж 164,639.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Соёлын өвийн үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 51,260.1 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 33,836.7 мянган төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал болон тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,403,439.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,403,439.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 704,696.9 мянган төгрөгөөр бууруулж 698,742.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 29 арга хэмжээг санхүүжүүлэхээр 698,742.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 698,742.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 698,742.5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 579,709.9 мянган төгрөгийг зарцуулж, нэр данс зөрүүтэй гүйлгээ 1,916.9 мянган төгрөг, нийт 119,032.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 581,626.8 мянган төгрөг буюу 83.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 100,789.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардлыг 16,092.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 21.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 211.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 91,930.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 20,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 69,907.0 мянган төгрөг, нийт 181,837.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 7,594.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 558.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 6,223.2 мянган төгрөг, томилолтын зардалд 10,896.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 139,867.9 мянган төгрөг нийт 165,140.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 16,697.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 164 мэдээллээс хугацаандаа оруулсан 136 мэдээлэл, 28 мэдээллийг хугацаа хоцроож, 21,621.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 863.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	863.5	1	863.5	0	0	100%
Нийт дүн	1	863.5	1	863.5	0	0	100%

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24,667.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,460.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 21,261.3 төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 946.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн бүртгэлд 99.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй байсныг залруулав.

Үндсэн хөрөнгийн шилжүүлэлтээс үүссэн гарзыг санхүү байдлын тайланд засгийн газрын сангаас 2,361.1 мянган төгрөгөөр хорогдуулсныг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 21,261.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд 21,261.3 мянган төгрөгийн түрээсийн мэдээллийг байршуулаагүй нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг, гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээлэх заалт, Эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 946.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, урьдчилж гарсан зардлын тооцоо болон и баримтын бүрдлийг хянах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 80 аж ахуйн нэгж хувь хүнтэй хийсэн худалдан авалтын дүнг и баримттай тулган шалгахад Монгол шуудан ХК-ийн 14 удаагийн 946.2 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрийг и баримтгүй шилжүүлсэн нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Цахим баримтаар баталгаажуулаагүй баримтаар гүйлгээ хийсэн байх.

1.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна. Хуульд заасны дагуу анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, бүртгэлд тусгаж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, дахин давтахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, нягтлан бодогч Ч.Өнөртогтох, болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			САГ-2021/50/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Соёлын өвийн үндэсний төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд оруулбал зохих 164 мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож, 21,621.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	21,261.3	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г.Энхбат Ч.Өнөртогтох
2	Тайлант онд 80 аж ахуйн нэгж хувь хүнтэй хийсэн худалдан авалтын и баримттай тулган шалгахад Монгол шуудан ХК-ийн 14 удаагийн 946.2 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрийг и баримтгүй шилжүүлсэн.	946.2	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Г.Энхбат Ч.Өнөртогтох
ДҮН		22,207.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 198/А-0170069
САГ/2021/50/СТА-7445

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 164 мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож, 21,261.30 /хорин нэгэн сая хоёр зуун жаран нэгэн мянга гурван зуу/ төгрөгийн ажил гүйлгээний мэдээллийг орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитыг тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, нягтлан бодогч Ч.Өнөртогтоход даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Ч.ЭНХЧИМЭГ

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a conclusion.